



ДОРНОД АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: ДОА-2018/01/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар харилцана уу:

Цахим хаяг: www.audit.mn

Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул

Утас: 7058-45203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер В.Цэнгэлмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Агуулга

1. ОРШИЛ	2
1.1. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	2
1.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	3
1.3. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, үр дүн	3
1.4. Дотоод хяналт	4
1.5. Шилэн дансны мэдээлэл	5
2. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА	5
2.1. Мөнгөн хөрөнгө	5
2.2. Төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл	6-7
2.3. Бараа материалын бүртгэл, тайлагнал	7-8
2.4. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал	8-9
2.5. Авлагын бүртгэл, тайлагнал	9-10
2.6. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал	10-11
2.7. Хуримтлагдсан үр дүн дансны бүртгэл, тайлагнал	11
2.8. Засгийн газар сан дансны бүртгэл, тайлагнал	11
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	12
3. ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРУУДЫН ТАЛААР	12
3.1. Сумдын Эмийн эргэлтийн сан	12
3.2. Сумдын орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	13
4. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	13
4.1. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.2. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	14
4.3. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	14
5. ЗӨВЛӨМЖ	14-15

1. Оршил

Дорнод аймгийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагыг баримтлан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тусгасан.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 14 сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 92 төсөвт байгууллага, аймгийн 8 төсөвт байгууллага, Засаг даргын нөөцийн сан, халамжийн сан, аймгийн орон нутгийн хөгжлийн сан, 14 сумын сум хөгжүүлэх сан болон орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн өмчит 5 үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит 13-н сумын эмийн эргэлтийн сангийн тайлан нэгтгэгдсэн байна.

1.1. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг үндэслэн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Засаг дарга М.Бадамсүрэн 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 1/522 дугаар албан бичгээр Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт хуулийн хугацаанд ирүүлсэн.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 01-нээс 2017 оны 4 дүгээр сарын 18-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 20-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, Ж.Баяртуул, аудитор С.Энхбаатар нар гүйцэтгэлээ.

1.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний удирдлагын тогтолцоо, эрх хэмжээ, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалттай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.” гэж үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17-д “аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн төсвийн” гэж заасны дагуу Дорнод аймгийн Засаг дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

1.3. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын Олон Улсын Стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Санхүүгийн хяналт аудитын албаны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 1.4-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 11 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2006 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэж байна

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн “Э-тайлан” программ хангамжийг ашиглажээ.

1.4. Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн Засаг даргын 2014 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Б/56 дугаар захирамжаар байгуулагдсан байна. Ажиллагсдын тоо: 12

Санхүүгийн хяналт, аудитын алба нь тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 174 байгууллагуудад 9 удаагийн хяналт шалгалт хийн 2,6 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 824,1 сая төгрөгийн зөрчилд 138 төлбөрийн акт тогтоож, 1,8 тэрбум төгрөгийн зөрчилд 117 албан шаардлага өгч ажилласан байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь төсвийн ерөнхийлөн захирагчтай 2017 онд 21 арга хэмжээ бүхий “Үр дүнгийн гэрээ”-г байгуулан, гэрээний биелэлтийг 97,9 хувьтай дүгнүүлэн ажилласан байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Тус алба нь Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харъяаны төсвийн шууд захирагчдийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, санхүүгийн тайлан, Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлж, эрсдэлийн удирдлагаар хангах ажлыг эрхлэн гүйцэтгэж байна.

1.5. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь Монгол Улсын “Шилэн дансны тухай” хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөж эхэлснээс хойш хэрэгжүүлэн өөрийн вэб хуудсанд “Шилэн данс”-ны цэсийг оруулсан байна.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлсэн байна.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)
4. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)
7. Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
8. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)
9. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагууд нь 2017 онд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар болон Санхүүгийн хяналт, аудитын албанаас “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн хяналт, шалгалтаар 92,3% хувьтай дүгнэгдсэн байна.

2. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

2.1. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1,2 дахин өсч 6,523.6 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд 70,6 хувь буюу 4,603.3 сая төгрөг төрийн санд, 29,3 хувь буюу 1,909.4 сая төгрөг арилжааны банкинд, 0,1 хувь буюу 10.9 сая төгрөг касст байна.

Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
МӨНГӨН ХӨРӨНГӨ ДҮН	5,373,737,475.69	6,523,620,988.50
Кассад байгаа бэлэн мөнгө	3,879,004.85	10,923,827.43
Төгрөг	3,879,004.85	10,923,827.43
Банкинд байгаа бэлэн мөнгө	5,369,858,470.84	6,512,697,161.07
Төгрөг	5,369,837,766.43	6,512,697,161.07
Төрийн сангийн харилцах	3,797,842,431.78	4,603,263,444.36

Арилжааны банк дахь харилцах	1,571,995,334.65	1,909,433,716.71
Гадаад валют	20,704.41	0.00
Арилжааны банк дахь харилцах	20,704.41	0.00

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн нийт үлдэгдлийн 14,9 хувь буюу 975.9 сая төгрөг төсөвт байгууллагууд, 52,7 хувь буюу 3,424.5 сая төгрөг төрийн санд, 3 хувь буюу 215.9 сая төгрөг төсөл сангуудад, 29,4 хувь буюу 1,907.2 сая төгрөгийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд бүртгэн тайлагнасан байна.

Харилцах дансны оны эхний үлдэгдэл, төсвийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулан орон нутгийн төсвийн зарлагын сар, улирлын хуваарийг төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулан аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 3,534.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагуудын санхүүжилтэд 21,560.2 сая төгрөг, хөрөнгө оруулалт, их засварын төсөл арга хэмжээнд 5,043.8 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлсэн байна.

2.1.2. Мөнгөн хөрөнгийн дансад илэрсэн алдаа, зөрчил

1. Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ нь кассаар бэлэн мөнгө хүлээн авдаг боловч кассын дэвтэр хөтлөөгүй.

2. Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ нь 2018.03.01-ний өдөр кассын тооллого хийж санхүүгийн баримттай тулган үзэхэд эхний үлдэгдлийг дутуу илэрхийлсэн, орлогыг дутуу бүртгэсэн, кассын дэвтэр хөтлөөгүй байсан.

Энэ нь төсвийн байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журмын хуулийн 5.3 дахь заалттай нийцэхгүй байна.


Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг байгууллагуудын удирдлагад өгсөн.

2.2. Бараа материалын бүртгэл, тайлагнал

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд бараа материалын үлдэгдэл 6,775.6 сая төгрөгөөр тайлагнагдсан нь өмнөх онтой харьцуулан үзэхэд 768,6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

№	Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эсөлт
				/бууралт/
1	Тусгай зориулалттай материал	493,135.6	554,357.5	61,221.9
2	Эм боох материал	142,818.8	207,149.5	64,330.7
3	Дуусаагүй үйлдвэрлэл	10,803.7	10,803.7	0
4	Бэлэн бүтээгдэхүүн	3,210.0	10,333.5	7,123.5
5	Бичиг хэрэг	143,256.8	200,502.9	57,246.1
6	Аж ахуйн материал	1,828,864.6	2,005,844.7	176,980.1
7	Сэлбэг хэрэгсэл	89,811.6	110,420.7	20,609.1
8	Түлш, шатах тослох материал	124,998.1	67,625.8	(57,372.3)
9	Барилгын засварын материал	12,920.2	12,411.0	(509.2)
10	Хүнсний материал	16,765.3	7,681.3	(9,084.0)
11	Бусад хангамжийн материал	1,525,399.4	1,940,736.7	415,337.3
12	Мал амьтад	1,595,042.5	1,627,739.4	32,696.9
	Нийт дүн	5,987,026.8	6,755,606.7	768,579.9

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 6,220.8 сая төгрөгийн бараа материал худалдан авсан бөгөөд хандив тусламжаар 267,9 сая төгрөгийн, бусад эх үүсвэрээр 521,6 сая төгрөгийн, шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр 310,7 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, тайлант онд 6,553.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.



2.2.2. Бараа материалын дансанд илэрсэн алдаа зөрчлүүд:

1. Баяндун сумын ЗДТГ, Баян-Уул сумын ЗДТГ, Баяндун сумын ЭЭС, Цагаан-Овоо сумын ЭЭС нийт 64,9 сая төгрөгийн бараа материалыг нярвын тайланд зөрүүтэй тусгасан.
2. Орон нутгийн өмчийн газар, Булган сумын ИТХ, Булган сумын ЗДТГ, Баянтүмэн сумын ИТХ нь нийт 5,67 сая төгрөгийн бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн.
3. Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ нь НББ-ийн хуулинд заасан шаардлагад нийцүүлэн хөтөлж бүртгээгүй 26,1 сая төгрөгийн үнийн дүн бүхий хятад баримт хавсаргасан анхан шатны баримттай байна.-НББ-ийн тухай хууль

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д. Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.

Шийдвэрлэсэн нь: Дээрх алдаа зөрчлүүдийг давтан гаргахгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах зөвлөмжийг холбогдох байгууллагын удирдлагад өгсөн.

2.3. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгө 109,295.6 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд өмнөх оноос 11.6 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгийн өөрчлөлтийг өмнөх онтой харьцуулахад барилга байгууламж 5,888.3 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 440.9 сая төгрөгөөр, зам гүүрийн байгууламж 2,940.7 сая төгрөгөөр, түүх соёл, музейн дурсгалт зүйлс 387.9 сая төгрөгөөр, бусад үндсэн хөрөнгө 2,103.8 сая төгрөгөөр, биет бус хөрөнгө 135,6 сая төгрөгөөр тус

тус өссөн бол автотээврийн хэрэгсэл 0,3 сая төгрөгөөр, тавилга, аж ахуйн эд хогшил 4,5 сая төгрөгөөр, батлан хамгаалахын тоног төхөөрөмж 1,3 сая төгрөгөөр, дуусаагүй барилга 4,567.8 сая төгрөгөөр, ном 34,3 сая төгрөгөөр тус тус буурсан байна.


/сая төгрөгөөр/

№	Үндсэн хөрөнгийн ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /бууралт/
1	Барилга, байгууламж, орон сууц	93,596.6	99,484.8	5,888.2
2	Автотээврийн хэрэгсэл	5,568.3	5,568.0	(0.3)
3	Машин тоног төхөөрөмж /компьютер/	9,516.0	9,956.9	440.9
4	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,610.3	4,605.8	(4.5)
5	Зам гүүрийн байгууламж	3,983.3	6,924.0	2,940.7
6	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	1.3	0	(1.3)
7	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,631.7	3,019.6	387.9
8	Бусад үндсэн хөрөнгө	13,760.6	15,864.4	2,103.8
9	Дуусаагүй барилга, байгууламж	16,634.3	12,066.4	(4,567.9)
10	Ном	256.8	222.5	(34.4)
11	Программ хангамж	146.9	234.0	87.1
12	Бусад бие бус хөрөнгө	572.0	620.4	48,4
	Нийт хөрөнгө	151,278.1	158,567.1	7,288.6

Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдлийн 94.5 хувийг биет хөрөнгө, 0.05 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Тайлант хугацаанд 15,782.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг нэмэгдүүлэн бүртгэсэн байгаа бөгөөд үүнээс төсвийн хөрөнгөөр худалдан авсан 702.2 сая төгрөг, хандив тусламжаар 1,530.2 сая төгрөг, шилжүүлж авсан 5,712.7 сая төгрөгөөр, бусад 7,837,6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Нийт үндсэн хөрөнгийн 62.7 хувийг барилга байгууламж, 3.5 хувийг автотээврийн хэрэгсэл, 6.3 хувийг машин тоног төхөөрөмж, 2.9 хувийг тавилга, 4.4 хувийг зам гүүрийн байгууламж, 1.9 хувийг түүх соёлын дурсгалт зүйлс, 10.0 хувийг бусад үндсэн хөрөнгө, 7.6 хувийг дуусаагүй барилга байгууламж, үлдсэн 0,7 хувийг ном болон биет бус хөрөнгө тус тус эзэлж байна.



Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 43,691.5 сая төгрөг, тайлант хугацаанд 6,723.0 сая төгрөгийн элэгдэл нэмж байгуулан, тайлант оны эцсийн үлдэгдлийг 49,271.5 сая төгрөгөөр тайлагнасан байна.

2.3.2. Үндсэн хөрөнгийг дансанд илэрсэн алдаа зөрчлүүд:

1. Орон нутгийн төсвийн болон тусгай шилжүүлгийн байгууллагууд нь Засгийн газрын 2014 оны 297 тоот тогтоолоор хүчингүй болсон 2005 оны 233 дугаар тогтоолыг баримтлан үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцсон.
2. Гурванзагал сумын ЗДТГ нь 63,7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн ангилалыг буруу бүртгэсэн.
3. Цагаан-Овоо сумын ЗДТГ нь 153,0 сая төгрөгийн элэгдлийн зардлыг тооцоолоогүй.
4. Хэрлэн сумын ЗДТГ нь үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авахдаа зардлын дансыг бууруулан бүртгэсэн.
5. Халхгол сумын ЗДТГ нь ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн худгийг орлогод бүртгэхдээ 12,2 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн.
6. Матад сумын ИТХ нь 5,08 сая төгрөгийн хөрөнгийн ангиллыг шилжүүлэхдээ гарз үүсгэн бүртгэсэн.
7. Матад сумын ЗДТГ нь 5,68 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд зардалд бүртгэсэн, 7,5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн бараа материалын дансанд бүртгэсэн.
8. Дорнод НАА ОНӨААТҮГ нь тайлант онд 84,5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөлгүйгээр санхүүгийн тайланд бүртгэсэн.
9. Дорнод НАА ОНӨААТҮГ нь хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс нь 550,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба энэхүү дүн нь хэдэн онд ямар ямар хөрөнгөнд хийгдсэн, дахин үнэлэгдсэн хөрөнгүүд нь санхүүгийн тайланд байгаа эсэх нь тодорхойгүй.
10. Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ нь 00001676 бүртгэлийн дугаартай 20,8 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгийг орлогод авахдаа тухай хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг тайлант үеийн элэгдлийн зардлаар бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн байгууллагуудын удирдлагуудад үндсэн хөрөнгийн бүртгэл тооцооллыг хийхдээ НББ-ийн бодлогын баримт бичиг, УСНББОУС-17-г мөрдөж ажиллах зөвлөмжийг өгсөн.

2.4. Авлагын бүртгэл, тайлагнал

Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 4,277.3 сая төгрөг байгаагаас тайлант онд 52.9 сая төгрөгөөр буурч, оны эцэст 4,224.4 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт авлагын үлдэгдлийг нэр төрлөөр нь харуулбал:

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Хувь	/сая төгрөгөөр/		
			Эцсийн үлдэгдэл	Хувь	Зөрүү
Ажиллагчидтай холбогдсон авлага	11.0	0.3	9.5	0.3	-1.5
Төлбөртэй үйлчилгээний авлага	1.6	0.04	1.6	0.04	-
Байгууллагаас авах авлага	1022.5	23.9	812.4	19.2	-210.1
Хувь хүмүүсээс авах авлага	2981.0	69.7	3158.4	74.8	177.4
Бусад авлага	261.2	6.1	242.5	5.7	-18.7
Нийт дүн	4277.3	100.0	4224.4	100.0	-52.9

Нийт авлагын 74.8 хувь нь хувь хүмүүсээс авах авлага, 19.2 хувь нь байгууллагаас авах авлага, 0.3 хувь нь ажиллагчидтай холбогдсон авлага, 0.04 хувь нь төлбөртэй үйлчилгээний авлага, 5.7 хувь нь бусад авлага тус тус эзэлж байна. Нийт авлагын 5.4 хувь нь төсөвт байгууллагын, 86.4 хувь нь төсөл сангийн, 8.2 хувь нь ОНӨҮГ-ын авлага байна.

Нийт авлагын 80,9 хувийг СХС-гаас олгосон зээлийн авлага эзэлж байна.

Сум хөгжүүлэх сангийн авлагыг сумдаар харуулбал:

				/төгрөгөөр/
№	Сумд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	Баяндун	177,141,638	147,341,223	(29,800,415)
2	Баян-Уул	192,681,754	211,382,132	18,700,378
3	Баянтүмэн	209,107,307	179,063,720	(30,043,587)
4	Булган	134,212,595	152,834,595	18,622,000
5	Гурванзагал	137,365,801	139,778,597	2,412,796
6	Дашбалбар	122,714,292	220,172,501	97,458,209
7	Матад	309,758,056	286,554,672	(23,203,384)
8	Сэргэлэн	146,682,622	196,002,053	49,319,431
9	Халх гол	190,805,632	226,608,662	35,803,030
10	Хөлөнбуйр	186,355,522	202,582,275	16,226,753
11	Хэрлэн	1,042,693,238	894,793,799	(147,899,439)
12	Цагаан-Овоо	216,473,850	223,663,043	7,189,193
13	Чойбалсан	98,441,300	167,209,850	68,768,550
14	Чулуунхороот	176,646,541	193,372,847	16,726,306
	Нийт дүн	3,341,080,148	3,441,359,969	100,279,821

2.4.2. Авлагын дансанд илэрсэн алдаа зөрчлүүд:

1.СХС-гаас олгосон эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн 1,4 тэрбум төгрөгийн авлагатай байна. Хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлага нийт авлагын 34,0 хувийг эзэлж байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тушаалаар батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2-д “Сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг сумын Засаг дарга хариуцна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: СХС-гийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тушаалаар батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллах албан шаардлагыг сумын төвлөрүүлэн захирагчидад хүргүүлсэн.

2. Мөн сумдын Эмийн эргэлтийн сангууд нийт 43,7 сая төгрөгийн авлагатай байна. Нийт авлагын 32,7 сая төгрөг буюу 74,8 хувь нь эмийн санчдаас авах он дамжсан авлага байна. Уг авлага нь нийт хөрөнгийн 54,5 хувийг эзэлж байгаа нь найдваргүй авлага бий

болох, байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах, албан шаардлагыг байгууллагын удирдлагуудад өгсөн.

3. Баян-Уул суман дахь сум дундын ойн анги он дамжсан 0,6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулалгүй бүртгэл, тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д Дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог баталгаажуулах” 20.2.6-д үлдэгдлийг баталгаажуулж, удирдах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах зөвлөмжийг өгсөн.

2.5. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3,801.1 сая төгрөг байгаагаас тайлант оны эцэст 3,946.7 сая төгрөг болж, 145.6 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт өр төлбөрийн 0.6 хувь нь ажилчидтай холбогдсон өглөг, 0.2 хувь нь бараа үйлчилгээний зардлын өглөг, 86.4 хувь нь хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг, 7.4 хувь нь байгууллагад төлөх өглөг, 5.0 хувь нь хувь хүмүүст төлөх өглөг, 0.3 хувь нь ОНӨҮГ-ын өглөг эзэлж байна.

Нийт өр, төлбөрийн үлдэгдлийг нэр төрлөөр нь харуулбал:

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Хувь	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
				Хувь	Зөрүү
Ажилчидтай холбогдсон өглөг	20.7	0.6	25.0	0.6	4.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	3.5	0.1	6.7	0.2	3.2
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	3411.2	89.7	3411.2	86.4	-
Байгууллагад төлөх өглөг	241.5	6.3	293.5	7.5	52.0
Хувь хүмүүст төлөх өглөг	121.5	3.2	197.2	5.0	75.7
ОНӨҮГ-ын өглөг	2.7	0.1	13.1	0.3	10.4
Нийт дүн	3801.1	100.0	3946.7	100.0	145.6

Нийт өр төлбөрийг байгууллагаар авч үзвэл 6.7 хувийг төсөвт байгууллагын, 6.1 хувийг төсөл сангийн, 87.2 хувийг ОНӨҮГ-ын өр төлбөр эзэлж байна.

2.5.2. Өр төлбөрийн дансад илэрсэн зөрчил

1. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны “Дорнод НАА”, “Чойбалсан хөгжил” орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын Азийн хөгжлийн банкнаас авсан зээлийн өглөг 3,411.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, зээлийн хүүгийн өглөгийг тооцоон тусгаагүй байна.

Энэ нь зээлийн эргэн төлөлт хийгдэх үед урьд онуудын тооцоогүй зээлийн хүүг бөөнөөр тооцсоноос зардлаар хүлээн зөвшөөрөх үед тухайн оны зардал өндөр гарах, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хүндрэл үүсэх эрсдэл өндөртэй байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөгийг барагдуулах, мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллах аудитын зөвлөмжийг төсвийн ерөнхийлөн захирагчид өгөв.

2. Мөн сумдын эмийн эргэлтийн сан нь 64,6 сая төгрөгийн өглөгтэй байгаа нь нийт хөрөнгөөс 7,7 хувиар давсан байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн яамнаас 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 7/153 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу сумын эмийн эргэлтийн сангуудыг эрүүл мэндийн төвд нэгтгэх, сангуудын өглөгийг барагдуулах зөвлөмж өгсөн.

2.6. Эздийн өмчийн дансдын бүртгэл, тайлагнал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хуримтлагдсан үр дүн 2016 оны эцэст 52,054.5 сая төгрөг байснаас тайлант онд 55,495.1 сая төгрөг болж 6,6 хувиар өссөн байна.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Хуримтлагдсан үр дүн	52,054,495,957.20	55,495,093,796.54	-1,800,338,022.41
Өмнөх үеийн үр дүн	52,054,495,957.20	50,254,157,934.79	-1,800,338,022.41
Тайлант үеийн үр дүн	-	5,240,935,861.75	

2.6.2. Эздийн өмчийн дансад илэрсэн алдаа, зөрчил

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар Засгийн газрын сан дансыг 791,5 сая төгрөгөөр бууруулж бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн Сайдын 2013 оны 269 дугаар “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” тушаалын 2 дахь заалтад “...Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар-ын 4.63 дахь заалтын “эсвэл Засгийн газрын оруулсан капитал гэснийг хассугай” гэж заасны дагуу зөвлөмж өгч аудит хийгдэж буй явцад ажил гүйлгээг залруулан тайлагнуулсан.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

2.7. Төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар

Аймгийн ИТХ нь 2017 оны төсөвт 3 удаа төсвийн тодотгол хийж төсвийн орлогын төлөвлөгөөг анх батлагдсанаас нь 1,046.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015-2017 оны 3 жилийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлд судалгаа хийж үзэхэд нийт дүнгээр 2015 онд 469.7 сая төгрөг, 2016 онд 1,666.6 сая төгрөг, 2017 онд 2,787.0 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Орлогын судалгааг хүснэгтээр харуулбал:

Орлогын нэр төрөл	2015 он	2016 он	2017 он
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	102.7	871.9	1132.1
Үйл ажиллагааны орлого	0	37.1	134.5

/сая.төгрөг/

Орлогыг нь тодорхойлох боломжгүй иргэний татвар	224.2	157.8	0
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	(50.9)	162.8	94.5
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар	37.5	61.7	12.5
Улсын тэмдэгтийн хураамж	0	(241.8)	379.1
Газрын төлбөр	0	2.8	57.8
Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр	(50.0)	(4.6)	98.8
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	0	43.1	12.2
Газрын дуудлага худалдаа	0	(211.7)	437.8
Байгалийн ургамал ашигласны төлбөр	270.0	91.8	33.3
Ус рашааны төлбөр	505.9	505.9	471.5
Ойн нөөц ашигласны төлбөр	9.0	9.0	30.7
Хүүгийн орлого	0	0	6.2
Торгуулийн орлого	272.8	272.8	234.6
Хөрөнгө худалдсаны орлого	(171.8)	(171.8)	20.5

Судалгаанаас үзэхэд автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар, байгалийн ургамал ашигласны төлбөр, ус рашааны төлбөр, ойн нөөц ашигласны төлбөр, торгуулийн орлого нь төлөвлөгөөнөөс 3,8 - 20,1 хувиар 3 жил дараалан давж биелсэн, бууны татвар нь 9.4 хувь буюу 4,7 сая төгрөг, нохойны албан татвар нь 87 хувь буюу 0,4 сая төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 7.3 хувь буюу 1,0 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Шалтгааныг тодруулбал:

- Бууны албан татварын хувьд галт зэвсэг эзэмшигч нь харьяа цагдаагийн байгууллагад шилжилт хөдөлгөөнийг тухай бүрт нь хийлгэдэггүй, иргэдийн гар дээр байгаа галт зэвсгийн мэдээлэл бодитой бус байгаа нь төлөвлөлтийг үндэслэлгүй хийх шалтгаан болж байна.
- Нохойны албан татварыг 2017 оноос баталсан боловч төлөвлөлт бодитой хийгдээгүй байна.
- Ан амьтны нөөц ашигласны төлбөрийг өмнөх жилүүдийн дунжийг үндэслэн хийдэг байна. БОАЖЯ нь тухайн жилд орон нутагт өгөх ангийн зөвшөөрлийг төсвийн орлогын төлөвлөгөө батлагдсаны дараа өгдөгтэй холбоотой байна.

2.7.2. Орлогын дансад илэрсэн алдаа, зөрчил

Сумдын ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа жигдрээгүй, тогтмол бус шинжтэй, орлогын эх үүсвэр тодорхойгүй, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөө байхгүй байгаа бөгөөд 8 сумын ОНӨААТҮГ нь нийт 164,3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна

Шийдвэрлэсэн нь: Сумдын өмчит газруудын үйл ажиллагааны болон орлого, зарлагын төлөвлөгөөг батлуулах аудитын зөвлөмжийг төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн.

2.8. Төсвийн зарлагын гүйцэтгэлийн бүртгэл, тайлагнал

Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 56,458.3 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 55,536.9 сая төгрөг болж 2 хувиар хэмнэгдэж нийт зарлагын 44,5 хувийг цалинд, 4,8 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 2,9 хувийг тогтмол зардалд, 34,7 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, 13,1 хувийг хөрөнгийн зардалд зарцуулжээ.

Харилцах дансны оны эхний үлдэгдэл, төсвийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулан орон нутгийн төсвийн зарлагын сар, улирлын хуваарийг ерөнхийлөн захирагчаар батлуулан аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 3,534.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагуудын санхүүжилтэд 21,560.2 сая төгрөг, хөрөнгө оруулалт, их засварын төсөл арга хэмжээнд 5,043.8 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлсэн байна.

Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтод олгосон 903,9 сая төгрөгийг цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын татварын төлөвлөгөө, гүйцэтгэлээс хасч тайланд тусгасан байна.

Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтод олгосон дүн өмнөх оноос 21,4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.8.2. Зардлын дансад илэрсэн алдаа, зөрчил:

1. Хэрлэн сумын 12 дугаар цэцэрлэг нь Шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт цалингийн сангийн зардлаас 2016 онд 1329697 төгрөг, 2017 онд 977413 төгрөг, нийт 2307110 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүү хяналт, дотоод аудитын албанд шилжүүлсэн.

2. Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургууль, Сум дундын ойн анги нь ажилчдын ээлжийн амралтын мөнгийг тооцохдоо 17,4 сая төгрөгөөр зөрүүтэй бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 16.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалын хавсралт 4-д “Ажилтанд олгож байгаа бүх төрлийн /жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвар алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөн олговор хөнгөлөлтийн орлого /унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй”, Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан “Ээлжийн амралтын олговор тооцох журам”-ын 7-д “Тухайн ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тодорхойлохдоо өмнөх ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тооцоход оруулсан хугацааны дундаж цалин хөлсийг давхардуулан оруулж тооцохгүй” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт, Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан “Ээлжийн амралтын олговор тооцох журам”-ын 7-г мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

3. ТЕЗ-ийн хүрээний 26 байгууллага сахилгын шийтгэлтэй ажилтнуудад нийт 27,2 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь УИХ-ын 2017 оны 67 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой ЗГ-аас өгсөн чиглэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3. САНАЛ, ДҮГНЭЛТИЙН ТАЛААР

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 132 байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулан санал дүгнэлт өгсөн.

Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Дүгнэлтийн хэлбэр				
	Санал дүгнэлт гаргасан	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
ТШЗ	37	36	1	-	-
Төсөл сан	2	2	-	-	-
Тусгай шилжүүлгийн байгууллага	63	61	2	-	-
ОНОААТҮГ	16	15	1	-	-
14 сумын нэгтгэл	14	14		-	-
Нийт дүн	132	128	4	-	-

- зөрчилгүй санал дүгнэлтийг-128 байгууллага
- хязгаарлалттай санал дүгнэлтийг – 4 байгууллага

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “..., **санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, ..., дүгнэлт авсан**, ... албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэсэн заалтын дагуу Баяндун сумын ЗДТГ, Хэрлэн сумын 3, 5 дугаар цэцэрлэг, Баянуул сумын ЭЭС-гийн удирдлагуудад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

4. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 2,453.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 791.5 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулан 1,634.5 сая төгрөгийн материаллаг бус алдаа, зөрчилд аудитын зөвлөмж өгч ажиллалаа. Эдгээр зөрчлийг асуудлын бүртгэлд нэгтгэж, баталгаажуулсан болно.

4.1. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар 5 зөвлөмж өгснөөс 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн нь 80 хувийн биелэлттэй байна.

Өмнөх зөвлөмжид СХС-гийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлагыг барагдуулах талаар зөвлөмж өгсөн ч 2017 онд энэ зөрчил дахин гарсан тул сумдын төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар СХС-гийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тушаалаар батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг

бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын хэрэгжилтийг хангах албан шаардлага хүргүүлсэн.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 69,274.3 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 1,385.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

4.3. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн Сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

5. ЗӨВЛӨМЖ:

- 5.1. Эрүүл мэндийн яамнаас 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 7/153 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу сумын эмийн эргэлтийн сангуудыг эрүүл мэндийн төвд нэгтгэх, сангуудын авлага, өглөгийг барагдуулах.
- 5.2. Аймгийн Засаг даргын 2018 оны 48 тоот захирамжаар баталсан Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудад баримтлах НББ-ийн бодлогын баримт бичиг, УСНББОУС-17-г мөрдөх, мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллах.
- 5.3. УИХ-ын тогтоол, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой гаргасан Засгийн газар болон холбогдох яам, дээд шатны байгууллагаас ирүүлсэн заавар, журмыг баримтлан ажиллах арга зүйгээр хангах.
- 5.4. Сумдын өмчит газруудын үйл ажиллагааны болон орлого, зарлагын төлөвлөгөөг батлуулах.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
ТАНАА

Аймгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн
нэгтгэсэн тайланд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж
ажиллах болно.



01 275

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН: ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Б.БОЛОРТУУЛ
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР	В.ЦЭНГЭЛМАА
БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР	Д.НАРМАНДАХ
	Ж.БАЯРТУУЛ
АУДИТОР	С.ЭНХБААТАР

Огноо: 2018.04.25